

ГРАНД СИСТЕМС ХХК

2024 оны 12 сарын 31-ний өдөр

№24/01

Улаанбаатар хот

“ГРАНД СИСТЕМС” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн “ГРАНД СИСТЕМС” ХХК (“Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

- Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралтаар баталсугай.
- Компанийн дүрмийг хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажилд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ЭНХБИЛЭГ

ГРАНД СИСТЕМС ХХК

2024 оны 12 сарын 31-ний өдөр

№ 24/03

Улаанбаатар хот

“ГРАНД СИСТЕМС” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн “ГРАНД СИСТЕМС” ХХК (“Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгон, томилсугай: Үүнд:

Ердийн гишүүд:

- О.Халтар
- О.Болд
- Э.Тэнүүн
- Б.Баярмаа
- Н.Лхамсүрэн
- Д.Энхбилэг

Хараат бус гишүүд:

- Н.Цэлмэгсайхан
- А.Батболд
- Р.Тогтохбаатар

- Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, журам, холбогдох бусад хэм хэмжээний актын шаардлагыг хангаж, хууль тогтоомж мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ЭНХБИЛЭГ

ГРАНД СИСТЕМС ХХК

2024 оны 12 сарын 31-ний өдөр

№24/02

Улаанбаатар хот

“ГРАНД СИСТЕМС” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ШИНЭЭР АВАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн “ГРАНД СИСТЕМС” ХХК (“Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

- Компанийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсугай.
- Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ЭНХБИЛЭГ